



ДУУРГИЙН БОЛОВСРОЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА НАРТ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БОЛОВСРОЛЫН ГАЗАР

Багшийн хөгжлийн ордон, Энхтайваны өргөн чөлөө 10а,
11 дүгээр хороолол, 8 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14191
Утас/Факс: (976) 7011-3033
<http://www.edub.edu.mn>

2019.08.28 № 4/1340
танай _____-ны № _____-т

Чиглэл хүргүүлэх тухай

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 2019-2020 оны хичээлийн жилийн албан ёсны статистик мэдээ, тайлан эхэлсэнтэй холбогдуулан дүүргүүдийн боловсролын хэлтэс, төрийн болон төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгүүдэд дараах чиглэлийг хүргүүлж байна. Үүнд:

Дүүргүүдийн боловсролын хэлтэст:

1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд албан ёсны статистик тоо мэдээг боловсруулах тайлагнах чиглэлээр арга зүйн дэмжлэг үзүүлэх;
2. Боловсролын салбарын мэдээллийн системд статистик мэдээг үнэн зөв, хугацаанд нь тайлагнахад хяналт тавьж ажиллах;
3. Статистик мэдээг сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлтэй тулгалт хийж хүлээн авах; /Хүчинтэй хугацаа, хаяг байршил, хүчин чадал гэх мэт/
4. Албан ёсны статистик мэдээг нэгж байгууллагуудаас цаасан болон цахим хэлбэрээр баталгаажуулж хүлээн авах.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд:

1. Албан ёсны статистик мэдээг хугацаанд нь үнэн зөв тайлагнах;
2. Сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн хүчин чадалд тулгуурлан статистик тоо мэдээг тайлагнах;
3. Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид 5 настай хүүхдийг элсүүлэхгүй байх; /БСШУС-ын сайдын 2019 оны А/200 дугаар тушаал/
4. Боловсролын салбарын мэдээллийн системд хүний нөөцийн мэдээллийг шинэчлэх, холбогдох мэдээллийг үнэн зөв оруулахад анхаарч ажиллах; /боловсролын түвшин, ажилласан жил, мэргэжлийн зэрэг гэх мэт/
5. Суралцагчдын бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг зохих журмын дагуу зохион байгуулах;
6. Боловсролын салбарын мэдээллийн систем ашиглалтын гарын авлагыг тогтмол ашиглах; /help.esis.edu.mn/

Дээрх чиглэлийг харьяа сургууль, цэцэрлэгүүдэд хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

ОРЛОГЧ ДАРГА



Л.БУЯНТОГТОХ

1110801012